

  
МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 4401

Мандалговь

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.11 дэх заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран "Стратегийн команд штабын сургууль"-ийг зохион байгуулахтай холбогдуулан Аймгийн Онцгой комиссын холбоо, зарлал мэдээллийн техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах зорилгоор Хөдөлгөөнт удирдлагын байрыг холбооны техник хэрэгслээр тоноглох шаардлагатай техник хэрэгслийг хавсралтаар баталсугай.

2. Шаардлагатай 19,858,000 (арван есөн сая найман зуун тавин найман мянга) төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтын гамшигийн эрсдэлийн санхүүжилтийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван), Ерөнхий санхүүч (С.Адъяасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Доржбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

МАНХБАЯР



Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар  
сарын 17.-ны өдрийн 11:44 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

**Аймгийн онцгой комиссын хөдөлгөөнт удирдлагын байрны  
зардлын тооцоо**

Д/д	Нэр, марк	Зориулалт	Нэг бүрийн үнэ	Тоо, ширхэг	Үнэ
1	Дэлгэц "42" инч	Голомтын зураглал хийж мэдээ мэдээллийг танилцуулах	800,000	1	800,000
2	Хэт богино долгионы гар станц	Ойрын зайнд холбоонд орж ажиллах	550,000	9	4,950,000
3	Богино долгионы суурин станцын хол зайд холбоо тогтоох зэл антен	Хол зайд холбоонд орох	1,100,000	1	1,100,000
4	Суурин компьютер Dell Optiplex 3000	Цахим хурал хийхэд	2,900,000	1	2,900,000
5	Нөутбүүк	Байнгын цахилгаан тэжээлд холбох шаардлагагүй зөөврийн байдлаар гадна ашиглах боломжтой	2,300,000	1	2,300,000
6	Иридиум	Холбоонд орох	2,310,000	1	2,310,000
7	Гэр интернэт	Утасгүй хөдөлгөөнт интернэтийн үйлчилгээг сонгон ашиглах боломжтой.	450,000	1	450,000
8	Микрофонтой камер	Цахимаар холбогдоход суурин компьютерт ашиглах	155,000	1	155,000
9	PTZ CAM4K	Видео 4K PTZ хурлын төхөөрөмж	1,200,000	1	1,200,000
10	Онлайн хурлын микрофон	Санал дүгнэлт, нөхцөл байдал танилцуулах	350,000	1	350,000
11	220в /мотор/	Техник хэрэгслийг тэжээлээр хангах	1,000,000	1	1,000,000
12	Цахилгааны утас, кабель	Тэжээлийн кабель холбох	10,000	60	600,000
13	Хэт богино долгионы машины станц	Ойрын зайнд холбоонд орж ажиллах 40-50км -т гар станцтай хамтран ажиллах	890,000	1	890,000
14	Холбох хэрэгслүүд	Бусад хэрэгсэл			853,000
<b>НИЙТ ДҮН</b>					<b>19,858,000</b>